



НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/66

Улаанбаатар хот

「 Баянгол дүүрэг дэх Цагдаагийн газрын  
балансад бүртгэлтэй барилгыг акталж,  
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 201 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/37 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2020 оны 415 дугаар магадлалын дагуу, Баянгол дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 17,232,925 (арван долоон сая хоёр зуун гучин хоёр мянга есөн зуун хорин тав) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан барилгыг актлан, данс бүртгэлээсээ хасаж өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Баянгол дүүрэг дэх Цагдаагийн газар (М.Батсайхан)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасадаж буй барилгыг буулгахад гарах хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулахаар үнэлсэн 1,707,200 (нэг сая долоон зуун долоон мянга хоёр зуу) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлэхийг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.


ДАРГА



М.БАЯРАА

115050000185

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын  
даргын 2022 оны 02 дугаар сарын  
17-ний өдрийн А/66 тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА,  
БАЙГУУЛАМЖ

/төгрөгөөр/

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Байршил	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Тайлбар
1	Цагдаагийн кабоны барилга	2004	БГД-ийн 21дүгээр хороо, Горькийн 25-1077 тоот	17,232,925.00	488,504.62	16,744,420.38	Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2020 оны 415 дугаар магадлалын дагуу
		Нийт		17,232,925.00	488,504.62	16,744,420.38	